



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 06 дугаар сарын 06

Дугаар 16/04

Баян-Өндөр сум

**Мал эмнэлгийн үйлчилгээний зардлын  
норматив батлах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг хавсралтаар баталсугай.

2.Мал, амьтны халдварт өвчнөөс сэргийлэх яаралтай болон төлөвлөгөөт дархлаажуулалтыг тархвал зүйн судалгаанд үндэслэн төлөвлөлтийг оновчтой хийж, үйл ажиллагааны зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган батлуулж, санхүүжүүлэн ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Л.Уртнаст)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (М.Түмэнжаргал)-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 64 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024  
оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Ээлжит бус XVI  
хуралдааны 16/04 дүгээр тогтоолын хавсралт



**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ГҮЙЦЭТГЭХ  
МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН НОРМАТИВ**

№	Үйлчилгээний нэр төрөл	Малын төрөл	Хэмжих нэгж	Нэгж үнэ (төгрөг)
1.1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх				
1.1.1	Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга	Бод (тэмээ, адуу, үхэр, сарлаг)	Толгой	1,000
		Бог (хонь, ямаа)	Толгой	350
		Амьтан (гахай, нохой, муур)	Толгой	1,000
		Шувуу	Толгой	1,000

-- 000 --